

# Олон Улсын Харилцааны Дээд Сургууль

АЛТАН АРСАМЖ

## АЛТАН АРСАМЖ

ВОЛ.3

1/2000

Олон улсын шинжтэй нэр томъёоны тухайд

*Доктор /PhD/ Г. Эрхэмбаяр*

*Докторант Д. Нарангэрэл*

Олон улс түмний янз бүрийн хэлний тогтолцооны онцгой нэг хэсгийг бүрдүүлдэг олон улсын шинжтэй үгс нь шинжлэх ухаан, соёл, улс төр, урлаг спорт болон бусад салбарын янз бүрийн ойлголтыг илэрхийлж, дор хаяж өөр тогтолцоо бүхий гурван хэлэнд нэвтэрч хэрэглэгддэг онцлогтой. Ер нь ийм үгийн ихэнх нь сонгодог хэлүүд болох эртний ерөг, латин хэлний язгуур үндсэнд тулгуурлан үүссэн байна.

Олон улсын шинжтэй үгс нь түүхэн үзэгдэл юм. Учир нь аль нэг үндэстний үндэсний болон улс төрийн ухамсар хүчтэй өрнөсөн түүхийн тодорхой үед үүсч хөгждөг жамтай юм. Жишээ нь хуучин ЗХУ-ын өөрчлөн байгуулалтын үед "перестройка" гэсэн нэр томъёо олон хэлэнд тэр дотроо роман-герман хэлнүүдэд илүүтэй нэвтрэн хэрэглэгдэх болжээ.

Нэр томъёоны олон улсын шинжтэй сан хөмрөг нь дэлхийн улс түмний хэлнүүдийг "ойртоход" хүчтэй нөлөө үзүүлдэг. Ийм үгсийг ашиглан дэлхий нийт нэг хэл бий болгох оролдлого ч гарч байсан. Гэвч өнөөгийн өндөрлөгөөс харахад хэлний хөгжлийг "интернационалчлал" нь хэт өрөөсгөл болох нь тодорхой байна. Энэ нь хэлний социологийн судалгаанаас тодорхой харагдаж байна. Дунд зэргийн хэмжээтэй шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний өгүүлэлд олон улсын шинжтэй нэр томъёо ойролцоогоор 16,5%, сонин сэтгүүлийн нийтлэлд 13,7%, уран зохиолд 4,5% эзэлж буй нь дээр дурдсан санааг ямар нэг байдлаар баталж байгаа юм. Гэвч ийм үгс нь ямар ч хэлэнд хэлний бодит шаардлагын улмаас байнга нэвтэрч байдаг үзэгдэл Учир олон улсын шинжтэй нэр томъёог судалгаанаас гадна орхиж өрөөс

Болохгүй юм.

Оросын академич В.В. Виноградов Бүх холбоотын нэр томъёоны зөвлөлгөөн дээр нэр томъёог хэт европжуулж / евроцентризм/ ойлгож болохгүй бөгөөд латин, герег гаралтай ОУ шинжтэй үгсийг араб, хятад зэрэг хэлнээс гаралтай нэр томъёотой адилхан авч үзэх ёстой талаар өгүүлсэн байдаг. Орчин цагийн монгол хэлэнд буй олон улсын шинжтэй нэр нэр томъёоны гарвал, ангилалыг авч үзвэл монгол хэлний үгийн сан судлалд бас нэг алхам болох буйзаа.

**"АЛТАН АРГАЖМ"**

**а. Олон улсын харилцаа**

проф. Ж.Бор  
"Олон улсын бодлого зүйн онолын асуудлууд" ..... 3- 8  
доктор проф. Ж.Баясах  
"Монгол Хятадын харилцааны онцлог" ..... 9- 12  
Ph. Ж.Баясах  
"Mongolian culture, politics and media" ..... 13-18  
Б.Батзориг  
"How to deal with emerging powers?" ..... 19-25  
доктор. Я.Ганбаатар, доктор. Д.Энхбат  
"Хүн төрөлхтөний түүх бол нүүдлийн түүх мөн" ..... 26-35  
Д.Далайжаргал  
"Олон улсын терроризмын тухай ойлголт" ..... 36 - 47  
доктор. Д.Наран  
"Sino-Russian relations and security of Mongolia" ..... 48 - 51  
Амь. Х.Олзвой  
"Mongolia and China: friendship and friendly relations treaties (A researcher's analysis)" ..... 52 - 59  
БНХАУ-с Монголд суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд  
Хуан Зянчуй  
"БНХАУ-ын бие даасан, хараат бус, энх тайванч гадаад  
бодлого" ..... 60 - 73  
д/д-р, проф. Д.Хүүхэнбаатар  
"Чингис хаан ба хорезм (сартуул)-ын элчин харилцааны  
түүхээс" ..... 74 - 81  
Paul Meerts  
"Mongolia in the world" ..... 82 - 89  
SFS/NUM Д.Уламбаяр  
"The opening of Korea: the case of Korean – getman relations" 90-97  
SFS/NUM Д.Уламбаяр  
"Origins of Korean-french relations: a french far east/interest case"  
..... 98-108  
д/д-р. Ж.Урангуа  
"Төрд зүтгэсэн түүхт эмэгтэйчүүд Түмэдийн алтан ханы их Юнгэн

хатан" ..... 109 - 112  
магистрант Т.Ариунсанаа  
"Монгол улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй  
статус" ..... 113-122  
SFS/NUM Ц.Ганзориг  
"Republic of tehas (1836-1845)" ..... 123

**б. Орон судлал**

ШУ-ы доктор. М.Базаррагчаа  
"Бурхан халдуч" гэдэг үгийн гарал, бүтцийн онцлог ..... 124 -131  
Б.Гэрэлт-Ирээдүй  
"Хятад үгийг кирилл үсгээр галиглах асуудалд" ..... 132-140  
д/д-р. Д.Наран  
"Дундад зууны үеийн монголчуудын гадаад хэлний мэдлэг  
боловсрол" ..... 141-144  
С.Сүхээ  
Болзамол хэлний тухай" ..... 144-147  
SFS/NUM доктор. Ж.Урангуа, С.Хонгорзул  
"The present situation of teaching U.S. history at the national university  
of Mongolia" ..... 148-151  
д/д-р. Д.Энхбат "Русь" буюу "Орос" хэмээх нэрийн  
тайллага" ..... 152-155  
Жуков Олег.  
"Москватгийн ОУХДС-ийн сэтгэгдэл" ..... 156  
Матюшев Илья  
(Наадам) ..... 157  
Л.Н.Гумилев.  
"Россия – Монголия общность путиразность судьб" ..... 158  
SFS/NUM English 2 "B" M.Valborg  
"Fulbright international conference american culture and media "Televi-  
sion violence and children" ..... 162-167  
док. Эрхэмбаяр, Д.Нарангэрэл  
Олон улсын чанартай нэр томёоны тухайд ..... 168-169